

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	2
ҮАГ-ын Гүйцэтгэлийн	Ерөнхий зүйл	3
аудитын газар	Бүлэг 1 Хөрөнгө оруулалт жил бүр нэмэгдэж байгаа ч үр нөлөө, ач холбогдлыг нарийвчлан тооцоолохгүй байна	
<i>Газрын захирал:</i> Д.Ганбилэг	<i>Улсын төсвийн хөрөнгө оруулалт жил бүр нэмэгдэж байна</i>	4
<i>Аудитын менежер:</i> Х.Баярмаа	<i>Хөрөнгө оруулалтыг хөрөнгийн зардлын тогтоосон хязгаараас нэмэгдүүлж баталжээ</i>	5
<i>Ахлах шинжээч:</i> У.Баярмаа	<i>Төсөл, арга хэмжээний талаас илүү нь шинээр хэрэгжихээр байна</i>	6
<i>Ахлах аудитор:</i> С.Сэрчхорол Г.Цэдэнбалжир	<i>Төрөөс баримталж буй бодлого, чиглэлтэй уялдуулан төлөвлөжээ</i>	7
<i>Аудитор:</i> Д.Цэрэндорж <i>Шинжээч:</i> Ц.Эрдэнэчулуун Л.Батжаргал Ж.Оюунтуяа М.Доржмаа Д.Энхболд Ж.Ганчимэг Л.Авирмэд	<i>Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр нөлөө, ач холбогдлыг түвшин бүрт нарийвчлан тооцоолохгүй байна</i>	8
	Бүлэг 2 Төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, үр дүнг сайжруулахад төрийн бодлого дутагдаж байна	
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. www.mnao.mn	<i>Хэрэгжих үндэслэл муутай төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөөр байна</i>	10
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	<i>Хэрэгжилт, үр дүнг сайжруулахад хэд хэдэн хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байна</i>	11
	<i>Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулсан ч батлагдаагүй байна</i>	12
	<i>Санхүүжилт, тендерийн үйл ажиллагаа хангалтгүйгээс хэрэгжилтийн хугацаа хоцордог гэжээ</i>	14
	Дүгнэлт	16
ХАЯГ: Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр Улаанбаатар хот 15160 Монгол улс	Зөвлөмж	17
	Холбогдох байгууллагын санал	18
	Саналд өгөх тайлбар	20
	Ерөнхий аудиторын тушаал	21
	Хавсралтууд	22

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ҮХШХ	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДШ	Дулааны шугам
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЭЗС	Техник, эдийн засгийн судалгаа
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ЗТБХБЯ	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
УХОХ	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр
ЗТБХБ	Зам тээвэр, барилга, хот байгуулалт
ЭБЭХ	Эрдэс баялаг, эрчим хүч
ЭХГ	Эрчим хүчний газар
НЭЗ	Нийгэм, эдийн засаг
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ЗТБХБС	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
НХХС	Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайд
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар

УИХ-ын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэхүү дүн шинжилгээг хийлээ.

Дүн шинжилгээний зорилт, хамарсан хүрээ

2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийж дүнг УИХ-д танилцуулахад энэ ажлын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд улс орон нутаг, салбарын бодлоготой нийцсэн эсэх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд төлөвлөсөн ёсоор хэрэгжих боломжтой эсэх

Дүн шинжилгээг хийхэд Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн 1, 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт” болон “Улаанбаатар хотод олгох санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт”-д тусгагдсан 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн ажлыг хариуцан хэрэгжүүлж буй Төсвийн ерөнхийлөн захирагчид, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон төсвийн байгууллагууд хамрагдлаа.

Дүн шинжилгээний арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Дүн шинжилгээнд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж асуулга, лавлагаа, тайлбар мэдээ гаргуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны, хяналтын хэсгийн тайланг судалж шалгуур үзүүлэлт, бодит байдалтай харьцуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Дүн шинжилгээнд хамрагдсан 2012 онд шинээр хэрэгжих болон он дамжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг төсвийн 16 ерөнхийлөн захирагчдаас авч нэгтгэн тайланд тусгалаа.

2012 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын 242 төсөл, арга хэмжээг хамруулсан санал асуулгыг төсвийн 12 ерөнхийлөн захирагч болон НЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудаас авч нэгтгэн дүнг тайланд тусгав.

Дүн шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитыг хянан баталгаажуулах журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

БҮЛЭГ 1

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа ч үр нөлөө, ач холбогдлыг нарийвчлан тооцоолохгүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалт жил бүр нэмэгдэж байна

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт жилээс жилд өсөн нэмэгдэж 2012 онд өмнөх 2 жилийн нийт хөрөнгө оруулалттай тэнцэхүйц, 2008-2010 оны дунджаас 3 дахин их хэмжээний төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр байна. (График 1)



1.2. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр УИХ баталжээ.

1.3. Уг хуулийн 1 дүгээр хавсралтаар, улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх 3,788,463.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1587 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 1,489,567.8 сая төгрөгөөр санхүүжүүлэх, 2 дугаар хавсралтаар, Улаанбаатар хотод олгох санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлэх 217,475.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 21 төсөл, арга хэмжээг 118,000.0 сая төгрөгөөр санхүүжүүлэх жагсаалтыг тус тус баталсан байна.

1.4. 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүнгийн 92.7 хувь нь ТЕЗ-дэд, 7.3 хувь нь нийслэлд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд оногдож байна.

(сая төгрөгөөр)

Батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	2012 оны төсвийн хуулиар батлагдсан									
	ТАХ тоо	Төсөвт өртөг	2012 онд санхүүжүүлэх дүн	Нийт дүнд эзлэх хувь	Үүнээс					
					5 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй			5 тэрбум төгрөгөөс бага төсөвт өртөгтэй		
					ТАХ тоо	дүн	Нийт дүнд эзлэх хувь (6*100/3)	ТАХ тоо	дүн	Нийт дүнд эзлэх хувь (9*100/3)
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1 дүгээр хавсралт, ТЕЗ-дын	1587	3,570,987.9	1,489,567.8	92.7	127	804,501.5	54.0	1460	685,066.3	46.0
2 дугаар хавсралт, Улаанбаатар хотод	21	217,475.6	118,000.0	7.3	10	101,203.5	85.8	11	16,796.5	14.2
БҮГД	1608	3,788,463.5	1,607,567.8	100.0	137	905,705.0	56.3	1471	701,862.8	43.7

1.5. Улсын төсвөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад тус бүр нь 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий нийт 905,705.0 сая төгрөгийн 137


төсөл, арга хэмжээ батлагдсан нь төсвийн 56.3 хувь, төсөл, арга хэмжээний 8.5 хувийг эзэлж байна. (Төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт 1-ээс үзнэ үү)

1.6. Түүнчлэн 5.0 тэрбум төгрөгөөс бага төсөвт өртөгтэй нийт 701,862.8 сая төгрөгөөр санхүүжих 1471 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ батлагдсан нь 2012 оны хөрөнгө оруулалтын нийт дүнгийн 43,7 хувь, төсөл, арга хэмжээний 91,5 хувийг (1471*100/1608) эзэлж байгаа нь олон жижиг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг харуулж байна.

1.7. 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 32.4 хувийг нийслэлд, 5.7-8.1 хувийг Дундговь, Ховд, Өмнөговь, Өвөрхангай аймгуудад, 3.0-4.4 хувийг Завхан, Дорноговь, Баянхонгор, Хөвсгөл, Хэнтий, Төв, Увс аймгуудад, 2.0-2.4 хувийг Дорнод, Баян-Өлгий, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад хэрэгжих төсөл, арга хэмжээнд зарцуулахаар байна.

1.8. Хэрэгжих төсөл, арга хэмжээний тоогоор авч үзвэл, 2012 онд нийслэлд 242, Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл аймгууд 89-77, Увс, Ховд, Өвөрхангай, Төв, Булган, Сүхбаатар аймгууд 69-61, Завхан, Дархан-Уул, Баянхонгор, Архангай, Дорноговь, Дундговь, Хэнтий аймгууд 57-40 арга хэмжээ байна.

1.9. Орон нутагт хэрэгжих хөрөнгө оруулалтын арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн дээр дурдсан хувь хэмжээ болон тоон үзүүлэлтээс үзэхэд орон нутгийн хөгжлийн бодлогод нийцсэн гэхээсээ илүү хөрөнгийг жигд хүртээсэн байдал ажиглагдаж байна. (График 2) /сая төгрөгөөр/



*Эх сурвалж: Салбарын ангиллыг ҮХШХорооноос

1.10. 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн гол салбаруудаар авч үзвэл, 36.3 хувийг авто зам, гүүр, тээвэрт, 21.3 хувийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт, 16.3 хувийг ДЦС, ДШ сүлжээ барих болон эрдэс баялаг, эрчим хүчний салбарт, 5.3 хувийг барилга, хот байгуулалт, газрын харилцаанд, 4.4 хувийг хүнс, хөдөө аж ахуйд, 3.0 хувийг мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн салбарт, 1.9 хувийг байгаль орчин, аялал жуулчлалд зарцуулахаар төлөвлөжээ. (График 2)

Хөрөнгө оруулалтыг хөрөнгийн зардлын тогтоосон хязгаараас нэмэгдүүлж баталжээ

1.11. Улсын төсвийн нийт хөрөнгө оруулалтыг дотоод ба гадаад гэж хуваана. Үүнээс дотоод хөрөнгө оруулалтыг дотор нь улсын төсвийн хөрөнгийн зардал ба бусад гэж

ангилдаг бөгөөд 2012 оны хөрөнгийн нийт зардлын 84.0 хувийг төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт эзэлж байна.

1.12. Мөн 2012 онд дотоодын хөрөнгө оруулалтын зардлын 91.6 хувийг хөрөнгө оруулалтад, 0.1 хувийг тоног төхөөрөмж худалдан авахад, 3.7 хувийг их засварт зарцуулахаар төсөвлөжээ.

1.13. 2012 оны улсын төсвийн зарлагад хөрөнгө оруулалтын зардлын батлагдсан дүн дараах байдалтай байна.

2012 оны улсын төсвийн хөрөнгийн зардал		Дүн	Хөрөнгийн зардлын дүнд эзлэх хувь	Дотоодын хөрөнгө оруулалтын зардалд эзлэх хувь
Хөрөнгийн зардал		1,774,161.9	100.0	-
Дотоод хөрөнгө оруулалт		1,436,943.4		100.0
Хөрөнгө оруулалт	Төсвийн хөрөнгөөр	1,316,429.9	-	91.6
Тоног төхөөрөмж	санхүүжих	118,606.0	-	8.3
Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт		1,907.5	-	0.1
Хөрөнгийн шилжүүлэг: Төсөвт газрын их засвар		52,624.4	-	3.7
Хөрөнгө оруулалтын зардлын дүн /2+3+4+5+6/		1,489,567.8	84.0	

1.14. УИХ-аар 2012 оны ТЕЗ-дын төсвийн хязгаарыг “Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хууль”-иар 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталжээ. Үүнд 1,104,225.0 сая төгрөгөөр хөрөнгийн зардлын хязгаарыг тогтоон, үүнд багтааж төсвөө боловсруулахыг ТЕЗ нарт даалгасан байх ба 2012 оны төсвийн хуулиар 503,342.8 сая төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна. (Хавсралт 1-ээс үзнэ үү)

1.15. 23 ТЕЗ-дын багцад хөрөнгийн зардлын хязгаарыг нэмж баталсан бөгөөд үүний дотор ЗТБХБС-ынх 48.3, БСШУС-ынх 18.4, ЭМС-ынх 9.9, НХХС-ынх 5.2, Ерөнхий сайдынх 4.8, ЗГХЭГ-ын даргынх 3.8 хувиар тус тус өссөн байна.

1.16. ТБУСТХ-ийн 33.3-т “Улсын Их Хурал улсын төсөв батлахдаа зайлшгүй нөхцлийн улмаас гарсан том хэмжээний өөрчлөлтөөс бусад тохиолдолд нэгэнт зөвшөөрсөн төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөхгүй байх зарчмыг баримтлана” гэж заасан байна.

Төсөл, арга хэмжээний талаас илүү нь шинээр хэрэгжихээр байна

1.17. 2012 онд хэрэгжих 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий нийт 905,705.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 137 төсөл, арга хэмжээний 93.9 хувь хөрөнгө оруулалтын, 6.1 хувь тоног төхөөрөмжийн санхүүжилт байна.

1.18. Мөн дээрх төсөл, арга хэмжээний 61 нь буюу 51.0 хувь нь 2012 онд шинээр эхэлж, 76 нь буюу 49.0 хувь нь он дамжин хэрэгжихээр байна.

Үзүүлэлт		2012 онд хэрэгжих 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ								
		тоо	дүн	Дүнд эзлэх хувь	Үүнээс:					
					Хөрөнгө оруулалт			Тоног төхөөрөмж		
А		1	2	3	тоо	дүн	Хувь (5*100/2)	тоо	дүн	Хувь (8*100/2)
Нийт төсөвт өртөг			2,652,219.6							
Аудитад хамрагдсан	нийт	137	905,705.0	100.0	128	850,193.0	93.9	9	55,512.0	6.1
	Он дамжсан	76	444,013.8	49.0	75	440,461.8	51.8	1	3,552.0	6.4
	2012 онд шинээр эхлэх	61	461,691.2	51.0	53	409,731.2	48.2	8	51,960.0	93.6

1.19. 2008-2012 онд эхэлж 2-10 жилийн хугацаагаар үргэлжлэн хэрэгжих 53 төсөл, арга хэмжээ байна.

1.20. 2012 онд шинээр эхлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий 61 төсөл, арга хэмжээний 88.8 хувь нь барилга, байгууламж барих, шинэчлэл хийх, 11.2 хувь нь тоног төхөөрөмж бэлтгэхээр байгааг ТЕЗ-аар харуулбал:

(сая төгрөгөөр)

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	2012 онд санхүүжих	үүнээс	
					Хөрөнгө оруулалт	тоног төхөөрөмж
XII	Монгол Улсын Ерөнхий сайд	7	105,435.0	28,999.2	28,999.2	-
XIII	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд	1	8,023.0	6,017.0	6,017.0	-
XVI	Гадаад харилцааны сайд	2	36,380.9	3,210.0	3,210.0	-
XVII	Сангийн сайд	1	12,150.0	12,150.0	-	12,150.0
XVIII	Хууль зүй, дотоод хэргийн сайд	2	13,709.6	5,800.0	5,800.0	-
XIX	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд	7	71,460.4	10,350.0	10,350.0	-
XX	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд	18	537,986.5	201,359.5	196,859.5	4,500.0
	УЛААНБААТАР хот	10	196,334.2	101,203.5	101,203.5	-
XXI	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	3	34,110.0	22,210.0	1,200.0	21,010.0
XXII	Эрүүл мэндийн сайд	3	24,100.0	11,280.0	480.0	10,800.0
XXIII	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	1	30,100.0	30,100.0	30,100.0	-
XXIV	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	5	50,151.0	18,875.0	15,375.0	3,500.0
XXV	Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд	1	11,137.0	11,137.0	11,137.0	-
	НИЙТ ДҮН	61	1,131,077.6	461,691.2	409,731.2	51,960.0
	Дүнд эзлэх хувь			100.0	88.8	11.2

1.21. 2012 онд шинээр эхлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 71.6 хувийг дэд бүтцийн салбарт буюу шинээр барих зам, гүүр, харилцаа, холбоо, мэдээллийн сүлжээ барьж эхлэх, “Улаанбаатар төмөр зам”-ын дүрмийн санг нэмэгдүүлэх, Улаанбаатар хотын бүтээн байгуулалт, зам, эрчим хүчний шугамыг барьж эхлэх, агаарын бохирдлыг бууруулах зэрэгт зарцуулахаар байна.

Төрөөс баримталж буй бодлого, чиглэлтэй уялдуулан төлөвлөжээ

1.22. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар хууль болон хөгжлийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 25.7-д төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлахыг УИХ... өөрийн онцгой эрхэд хадгалж шийдвэрлэнэ,
- 2008 онд батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын баримт бичигт Улсын төсвийн бодлого нь эдийн засгийн өсөлт болон төсөв санхүүгийн тогтвортой, тэнцвэрт байдлыг бататгаж, санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бодит салбарын хөгжлийг дэмжихэд бүрэн чиглэнэ. Төсвийн бодлогыг Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ,
- УИХ-ын 2008 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт, ...хөтөлбөрт туссан зорилтуудыг жил бүрийн төсвийн хүрээний мэдээгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан,
- Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 343 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай баримт бичгийн 3.а-д Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасан байна.

1.23. Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн бодлогын баримт бичигт хэрхэн тусгагдсаныг ТЕЗ-аар харуулбал:

	Төсвийн ерөнхийлөн захирагчид	Тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо				Монгол Улсын НЭЗ-ийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд
		Бүгд	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод	Үндэсний хөгжлийн цогц бодлогод	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт	
1	Монгол Улсын Ерөнхий сайд	11	10	10	11	11
2	Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд	1	1	1	1	1
3	Монгол Улсын Шадар Сайд	2	1	1	2	-
4	Гадаад харилцааны сайд	2	-	2	2	2
5	Сангийн сайд	2	-	-	2	-
6	Хууль зүй, дотоод хэргийн сайд	5	-	-	4	4
7	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд	20	-	20	20	20
8	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд	51	-	51	51	51
9	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	14	11	13	14	13
10	Эрүүл мэндийн сайд	7	6	7	7	6
11	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	1	-	-	1	-
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	8	-	8	8	8
13	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	1	1	1	1
14	Батлан хамгаалахын сайд	2	-	2	2	2
15	Улаанбаатар хот	10	1	10	10	9
	Нийт дүн	137	31	126	136	128
	Нийт дүнд эзлэх хувь		42.4	92.0	99.3	93.4

1.24. Дүн шинжилгээнд хамрагдсан 137 төсөл, арга хэмжээний дийлэнх буюу 92.0-99.3 хувь Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр нөлөө, ач холбогдлыг түвшин бүрт нарийвчлан тооцоолохгүй байна

1.25. Олон улсын жишгээр томоохон төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ салбарын суурь судалгааны ажилд үндэслэх, холбогдох байгууллагуудын саналыг шат шатанд нэгтгэн боловсруулах, тухайн арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагатай гэдгийг хэмжих үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг оновчтой тодорхойлох, урьдчилсан тооцоолол судалгааг хийх, төсөл хөтөлбөрийн нийгэм болон салбар, хэрэглэгчдэд үзүүлэх үр нөлөө, үр ашгийг хэрхэн тооцоолсон байдал зэрэг үзүүлэлтийг харгалздаг байна.

1.26. Дээр дурдсан үзүүлэлтүүдийг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хэрхэн харгалзаж тусгасныг холбогдох яамдаас санал асуулга авч нэгтгэн дүгнэхэд дараах байдалтай байна. Үүнд:

а) Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ салбарын судалгаа шинжилгээний ажлыг хэрхэн ашигладаг талаарх асуултад судалгаанд оролцогчдын 90.0 хувь салбарын холбогдох мэдээлэлд байнга тулгуурладаг, 3.5 хувь ямар нэгэн судалгаа мэдээлэлд тулгуурладаггүй гэсэн хариултыг өгчээ.

б) Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд холбогдох байгууллагын саналыг хэрхэн тусгадаг вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 78.3 хувь салбарын анхан шатны байгууллага, ТББ, иргэдийн

саналыг авч тодорхой хэмжээнд тусгадаг гэж хариулсан бол 5 төсөл арга хэмжээ тутмын нэг нь холбогдох байгууллагын саналыг хангалттай тусгаж чаддаггүй гэж хариулжээ.

с) Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэн шаардлагатай байгааг тодорхойлоход доорх үзүүлэлтүүд голлох байр суурьтай байна. Судалгаанд оролцогчид нийт 45 үзүүлэлтийг дурдсан ба хамгийн олон давтамжтай үзүүлэлтийг үзүүлэв. (График 3)



1.27. Графикаас багцлан авч үзвэл улсын болон бүс нутгийн хөгжил, өсөн нэмэгдэж буй хэрэгцээ тэргүүлэх үзүүлэлт байгаа бол хоёрдугаарт шинэ технологийн нэвтрэлт, нийгэм эдийн засгийн хэрэгцээ, үндэсний томоохон хөтөлбөрийг дэмжсэн байдал зэрэгт ач холбогдол өгч, гуравдугаарт салбарын болон орон нутгийн хэрэгцээ, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, эдийн засгийн үр ашгийг тус тус эрэмбэлэн авч үзжээ.

1.28. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж сонгоход урьдчилсан судалгааг хэрхэн хийдэг талаарх асуултад судалгаанд оролцогчдын 51.3 хувь салбарын харъяа нэгжүүд өөрсдөө гаргадаг, 42.0 хувь нэгж агентлагуудын санал мэдээллийг салбарын яам нэгтгэн мэдээллийн санд оруулдаг, 4.6 хувь УИХ, Засгийн газрын хуралдаан дээр төсвийн хууль хэлэлцэхдээ хөрөнгө оруулалтын арга хэмжээг тодорхойлдог гэсэн хариултыг өгсөн байна.

1.29. Харин төсөл, арга хэмжээний эцсийн үр дүн, ач холбогдлыг түвшин бүрт тооцох тал дээр нэлээд дутагдалтай байгааг онцлон дүгнэж байна. Энэ нь судалгаанд оролцогчдын 51.7 хувь тухайн төсөл, арга хэмжээний үр нөлөөг улсын түвшинд тооцоолоогүй, 78.9 хувь ерөнхий байдлаар л салбарын түвшинд тооцоолдог, 16.7 хувь нь хэрэглэгчдэд ямар үр өгөөжтэйг нарийвчлан тооцоолдоггүй гэсэн хариултаас тодорхой байна.

1.30. Судалгаанд оролцогчдын түвшин бүрт тухайн төсөл, арга хэмжээний үр нөлөө, ач холбогдлыг хэрхэн тооцоолдог талаарх мэдээллийг багцлан үзвэл Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж буй байдал, салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр зэргийг чухалчилдаг байна. Харин зам тээвэр, барилгын салбарын арга хэмжээнд ТЭЗҮ-г нь сайн үздэг гэсэн хариулт голлож байна.

БҮЛЭГ 2

Төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, үр дүнг сайжруулахад төрийн бодлого дутагдаж байна

Хэрэгжих үндэслэл муутай төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөөр байна

2.1. 2012 онд хэрэгжих 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий 137 төсөл арга хэмжээний 13 буюу 9.5 хувь нь ТЭЗҮ байхгүй, 12 буюу 8.7 хувь нь газрын зөвшөөрөлгүй, 12 буюу 8.7 хувь нь инженер геологи болон геодезийн дүгнэлтгүй, 10 буюу 7.2 хувь нь техникийн нөхцөл аваагүй, 14 буюу 10.2 хувь нь боловсруулсан зураг төсөлгүй болон зураг төсөлд магадлал, экспертиз хийгдээгүй, 14 буюу 10.2 хувь нь батлагдсан төсөвгүй, 37 буюу 27.0 хувь нь сонгон шалгаруулалт хийгдээгүй болон ажил эхлэх зөвшөөрөл аваагүй байна. (Хавсралт 2)

2.2. 2012 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний 30.7 хувь буюу 3 арга хэмжээ тутмын нэг нь Барилгын тухай хуулийн 15.2-т “Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2010 оны 135 дугаар тушаалаар батлагдсан¹ журмын 2.2-т “Тухайн санхүүгийн жилд шинээр эхлэхээр тооцож буй төсөл, барилга байгууламж нь ...хайгуул нь хийгдэж дүгнэлт гарсан, зураг төслийн ажил нь экспертизээр батлагдсан, барилга барих газар болон инженерийн шугам сүлжээний асуудал бүрэн шийдэгдсэн, үр ашигтай нь техник-эдийн засгийн тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажил эхлэх нөхцлийг хангасан байна” гэснийг зөрчиж байна.

2.3. Хөрөнгө оруулалтын төслийн өртгийг өмнө нь хэрэгжсэн ижил төстэй төслүүдийн гүйцэтгэл болон “Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай” Засгийн газрын 2010 оны 336 дугаар тогтоолыг баримтлан бодитой тооцохгүй байна. Тухайлбал; ЗТБХБ-ын салбарт хэрэгжихээр төлөвлөгдсөн зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг жишиг үнээр тооцвол:

(сая төгрөгөөр)

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	Баталсан жишиг үнээр	Зөрүү
	ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД		408,805.8	344,407.9	(64,397.9)
ХIY	Мөрөн-Тэрхийн Цагааннуур чиглэлийн 100 км авто замын зураг төслийг бэлэн болгож ажлыг эхлүүлэх /Хөвсгөл/	2011-2014	45,000.0	42,600.0	(2,400.0)
ХIY.2.3	Улаангом /Тээлийн гүүр/-Хяргас нуур чиглэлийн 100 км авто замын зураг төслийг бэлэн болгож, замын ажлыг эхлүүлэх /Увс/	2011-2014	45,000.0	42,600.0	(2,400.0)
ХY.1.1	Налайх /4 дүгээр зөрлөг/-Зуунмод чиглэлийн 25 км хатуу хучилттай авто зам /Улаанбаатар/	2012-2013	14,475.2	10,650.0	(3,825.2)
ХYI	Хужирт-Төвхөн хийд-Улаанцутгалан чиглэлийн 90 км хатуу хучилттай авто зам /Өвөрхангай /	2012-2014	44,592.0	38,340.0	(6,252.0)
ХYI.1.1.1	Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км авто замын шинэчлэл /Улаанбаатар/	2012-2013	13,032.8	12,865.2	(167.6)
ХYIII.9	Нарийний голын 325 у/м төмөр бетонон гүүр /Увс,Тэс/	2011-2013	5,380.2	4,375.0	(1,005.2)
ХYIII.9.1	Үүрийн голын 350 у/м төмөр бетонон гүүр /Хөвсгөл, Цагаан-Үүр/	2011-2013	8,163.8	4,725.0	(3,438.8)
ХYIII.10	Хэрлэн голын төмөр бетонон гүүр /Дорнод, Хөлөнбуйр/ 344,2 у/м	2012-2014	6,200.0	4,646.7	(1,553.3)
ХYIII.1.1.6	Манхан-Дарви чиглэлийн 100 км, хатуу хучилттай авто зам /Ховд/	2010-2013	42,981.8	42,600.0	(381.8)
ХYIII	Даланзадгад-Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 251 км, хатуу хучилттай авто зам /Өмнөговь/	2010-2014	145,580.0	106,926.0	(38,654.0)
ХYIII.1.1.2	Хатгал-Ханх чиглэлийн 80 км, хатуу хучилттай авто замын зураг төслийг бэлэн болгох, ажлыг эхлүүлэх /Хөвсгөл/	2010-2014	38,400.0	34,080.0	(4,320.0)

2.4. Дээрх төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртгийг, хатуу хучилттай замын км тутамд 3.1-154.0 сая төгрөгөөр, гүүрийн байгууламжийн урт/метр тутамд 3.1-9.8 сая төгрөгөөр, нийт 64,397.9 сая төгрөгөөр тогтоосон жишиг үнээс илүү тооцож төлөвлөсөн байна.

¹ Улсын болон орон нутгийн төсөв тэдгээртэй адилтгах хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, гүйцэтгэл гаргах, санхүүжүүлэх, хяналт тавих журам

2.5. Тайлант жилд хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэх явцад үндсэн нэгжээс ирүүлсэн саналыг бууруулж баталснаас графикт хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон төсөл, арга хэмжээг дурдвал;

- ЗТБХБ-ын сайдын багцад батлагдсан Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах Олон улсын нисэх буудал барихтай холбогдсон Монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээний 2012 онд санхүүжүүлэх хэмжээг Японы Олон Улсын банкттай байгуулсан гэрээний дагуу 22,3 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн саналыг салбарын яам, Сангийн яам хянасныг 13,8 тэрбум төгрөгөөр,
- ЭБЭХЯ-нд хэрэгжих зураг төсөл, төсөв нь батлагдсан Эрдэнэт 220/110/35/6 кВ-ын дэд станцын хүчин чадлыг 2*200 МВА болгож нэмэгдүүлэх /Орхон/ 8.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг ЭХГ, ЭБЭХЯ, СЯ-наас 2012 онд санхүүжүүлэх саналыг 2.0 тэрбум төгрөгөөр төсвийн төсөлд оруулсан боловч 200.0 сая төгрөгөөр,
- ЭБЭХЯ-ны Газрын тосны газраас Газрын тосны бүтээгдэхүүний агуулах төслийг 22.7 тэрбум төгрөгөөр санал оруулсныг яамнаас 750.0 сая төгрөгөөр хянаж төсвийн хуулиар баталсан байна.

2.6. 2008 онд хатуу хучилттай Мөрөн-Хатгалын чиглэлийн 98.8 км замыг 5 жилд, 2010 онд Манхан-Дарви чиглэлийн 100 км замыг 4 жилд, 2011 онд Мөрөн-Тэрхийн Цагааннуур чиглэлийн 100 км, Улаангом (Тээлийн гүүр) -Хяргас нуур чиглэлийн 100 км замуудыг 5 жилд, 2012 онд Халзанбүргэдэй (Тариат)-Солонготын даваа чиглэлийн 100 км замыг 3 жилд тус тус барихаар төлөвлөсөн байна.

2.7. ЗТАЖ-ын сайдын 2007 оны 186 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Авто зам, замын байгууламж барих нормативт хугацаагаар тооцоход 100 км замыг 4 жил 3 сард барьж дуусгахаар байна.

2.8. Дээрх замуудын ажлын тоо хэмжээ адил ч хэрэгжих хугацааг жил бүр өөр өөр байдлаар төлөвлөсөн байна.

Хэрэгжилт, үр дүнг сайжруулахад хэд хэдэн хүчин зүйл сөргөөр нөлөөлж байна

2.9. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнг сайжруулах, төлөвлөлтийг боловсронгуй болгоход тэдгээрт нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлох нь чухал байна.

2.10. Дүн шинжилгээний ажлын хүрээнд авсан санал асуулгад дээрх асуудлыг авч үзэхдээ нийгмийн хүчин зүйлс буюу байгууллагын гадаад буюу дотоод хүчин зүйлс гэсэн 2 бүлэг асуудлаар тодорхойлохыг зорьсон болно.

2.11. Санал асуулгад оролцогчдын хариултын нийгмээс нөлөөлж буй сөрөг хүчин зүйлст *нэгдүгээрт*, үнийн өсөлт, эдийн засгийн тогтворгүй байдал (30 санал), *хоёрдугаарт*, улс төрийн хүчин зүйлийн нөлөөлөл (15 санал), *гуравдугаарт*, төслийн санхүүжилт удаашралтай, шаардлагатай хугацаандаа хийгддэггүй гэсэн шалтгаанууд тэргүүлж байгаа бол дотоод хүчин зүйлсэд төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч байгууллагын техникийн болон боловсон хүчний хангамж, чадвар дутагдах байдал гардаг, энэ нь тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэггүй байгууллагууд тендерт ялсан тохиолдолд ийм бэрхшээлүүд тохиолддог гэсэн хариултауд голлосон байна.

Нийгмийн хүчин зүйлс

Хариултын хувилбар	Саналын тоо (55)
Эдийн засгийн хүчин зүйлс	30
Үнийн өсөлт	12
Эдийн засгийн тогтворгүй байдал	18
Улс төрийн хүчин зүйлс	15
Тооцоо судалгаа, үндэслэл муутай зарим төсөл арга, хэмжээ төсвийн хуулиар батлагддаг	11
Зарим нэг төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс өөрөөр хэрэгждэг	4

Төслийн санхүүжилт удаашралтайгаас он дамжих, шаардлагатай хугацаандаа нийлүүлэлт хийгддэггүй	10
Төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу	6
Зам барилга угсралтын компаниудын техник, хүчин чадал хангалтгүй	5
Тендерийн тухай хуулийг боловсронгуй болгох хэрэгтэй	5
Яам, агентлагийн санал УИХ-аар батлагдахдаа өөрчлөгддөг	2
Хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах ба гүйцэтгэгчийг шалгаруулах үйл ажиллагаанд хэрэглэгчдийн оролцоо байдаггүй, үүнийг бий болгох	2

** Давтамж өндөртэй хүчин зүйлсийг эрэмбэлэн эхний хариултуудыг жагсаав*

Байгууллагын буюу дотоод хүчин зүйлс

Хариултын хувилбар	Саналын тоо (7)
Гүйцэтгэгч байгууллагын техникийн болон боловсон хүчний хангамж, чадвар дутмаг байдаг	3
Төсөлд ялахын тулд эдийн засгийн үр ашгийн тооцоог өндөр хийдэг	1
Зураг төслийг дахин хийх шаардлага гардаг	1
Мэргэжлийн байгууллагын судалгаа тооцоололгүй, улс төрчдийн саналаар үр өгөөж муутай төслүүдийг баталж хэрэгжүүлдэг	1
Тухайн чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй байгууллагууд сонгогдоход мэргэжлийн чадвар, хүний нөөцийн асуудал тулгардаг	1

2.12. Санал асуулгад оролцогчдын 17.1 хувь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд төлөвлөсөн ёсоор хэрэгжих боломжгүй гэсэн хариултыг өгсөн ба үүнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг дараах байдлаар дурджээ. Үүнд, 39.1 хувь тооцоо судалгаагүй амлалтаас шалтгаалан төлөвлөлт гажууддаг, 10.9 хувь төлөвлөлт муу, мөн 10.9 хувь хэрэгжилтийн хугацааг үндэслэлгүй төлөвлөснөөс биелдэггүй, 6.5 хувь төлөвлөлтийн учрыг ойлгодоггүй гэсэн шалтгаануудыг илүүтэй дурдсан байна.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулсан ч батлагдаагүй байна

2.13. Макро эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг дэмжсэн, дунд хугацааны хөтөлбөрт суурилсан төсвийн бодлого, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үйл ажиллагааг сайжруулах Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын дагуу хөрөнгө оруулалтын таван жилийн хөтөлбөр боловсруулан жил бүр тодотгох замаар эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлтэй хамтатган хэлэлцэж байхаар 2010 онд Засгийн газрын 123 дугаар тогтоол гарчээ.

2.14. Үүнийг үндэслэн ҮХШХ-ны даргын 2010 оны 137, 2011 оны 38 дугаар тушаалаар “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах, үнэлэх, эрэмбэлэх аргачлал”, “Төслийн техник, эдийн засгийн судалгаа хийх аргачлал”-ыг тус тус батлан “Улсын хөрөнгө оруулалтын 2011-2016 оны хөтөлбөр”-ийг боловсруулан 2011 оны 5 дугаар сарын 25-нд Засгийн газарт оруулсан боловч батлагдаагүй байна.

2.15. Уг хөтөлбөрийг Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгийн хязгаарыг баримтлан Хөгжлийн банк, бусад эх үүсвэрийг ашиглах замаар Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ бүтээн байгуулалтын дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд чиглүүлж, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслүүдтэй уялдуулан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх хөгжлийн тэргүүлэх чиглэлийн үндэслэл, Үндэсний хөгжлийн цогц бодлогын тэргүүлэх чиглэл, эдийн засгийн аюулгүй байдлын зорилт зэрэгт үндэслэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2011-2016 оны хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж боловсруулсан ажээ.

2.16. Түүнчлэн Сангийн сайдын 2010 оны 135 дугаар тушаалаар батлагдсан² журмын 2.5-д “Захиалагч яам, газар, аймаг нийслэлийн санхүүгийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээ, УХОХ-тэй харилцан уялдсан байхын дээр салбарын гол тэргүүлэх чиглэлд хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүлэн ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна” гэсэн нь УХОХ батлагдаагүй учир хэрэгжээгүй байна.

2.17. Мөн 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т зөвхөн 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй томоохон төслүүдийг хамруулахаар тусгасан нь энэ дүнд хүрээгүй төслүүдэд холбогдох шаардлага, шалгууруудыг тавих, улсын болон бүс орон нутгийн хөгжлийн бодлого, бусад төслүүдтэй уялдуулах асуудлууд орхигдоход хүргэж болзошгүй байна.

2.18. Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас эрдэс баялгийн нөөцийг бодит болон хүний капитал хөрөнгө болгон хувиргахын тулд Монгол Улс төсвийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийн шинэчлэл хийх шаардлагатайг зөвлөсөөр байна. Үүнд:

-эдийн засгийн давтамжид чиглэсэн, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд хэтэрхий дарамт үзүүлсэн шинжтэй, эдийн засаг огцом өсөх үед зарлага адилхан өсөж байгаа нь хөрөнгийн буруу хуваарилалт хийхэд хүргэж, төслүүдийг үнэлэх, сонгох систем нь зарлагатайгаа ижил хурдаар өсөж чадахгүй,
- Монгол Улсын төсөв нь нөөцийг сайн хуваарилаагүй, төсвийг нэн тэргүүнд шинэ барилгуудад хуваарилж, капитал хөрөнгүүдийг засахад бага хөрөнгө хуваарилж, капитал төслүүдийг үнэлэх, төсөвлөх асуудал хангалтгүй байгаа нь зохицуулах хууль, дүрэм, журам сул байгаатай холбоотой,
- төслийн мөчлөгтэй холбоотой асуудлуудын улмаас үр ашгийн хуваарилалтын асуудал үүсдэг зэрэг болно.

2.19. Мөн Дэлхийн Банкны Төсвийн хөрөнгө оруулалтын зарлагын гарын авлагад тодорхойлсноор “бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг хооронд нь холбохгүй байх нь хөгжиж буй орнуудад үйл ажиллагаа, стратеги, макро түвшинд төсөвлөлтийн муу үр дүнд хүргэх гол хүчин зүйл нь байна” гэжээ. /Эх сурвалж: ҮХШХ-оос/

2.20. Өнөөг хүртэл баримталж, хэрэгжүүлж буй улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь үндэсний, бүс нутгийн, салбарын бодлогын баримт бичгүүдтэй уялдаагүй, төсөл, арга хэмжээг зардал үр ашгийн шинжилгээний шалгуураар тэргүүлэх дарааллыг нь тодорхойлоогүй, олон төсөл арга хэмжээг нэгэн зэрэг бага хэмжээгээр эхлүүлж хөрөнгийг тарамдуулж үр ашгийг багасгадаг, үндсэн хөрөнгийн ба урсгал зардлын тооцоолол нь бодитой бус хийгддэгээс төсвийн тогтвортой байдлыг алдагдуулахаар байна.

2.21. Мөн төслийн өртгийг тооцоолоход техник, эдийн засгийн судалгаа хийх, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, зураг төсөв зохиох болон төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны бэлтгэл зардлуудыг урьдчилан бүрэн тооцож төлөвлөхгүй байгаагаас төслийн хэрэгжилтийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

² Улсын болон орон нутгийн төсөв тэдгээртэй адилтгах хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, гүйцэтгэл гаргах, санхүүжүүлэх, хяналт тавих журам

Санхүүжилт, тендерийн үйл ажиллагаа хангалтгүйгээс хэрэгжилтийн хугацаа хоцордог гэжээ

2.22. Судалгаанд хамрагдсан нийт төсөл, арга хэмжээний 80.8 хувь хугацаандаа хэрэгжиж 19.2 хувь ямар нэгэн шалтгааны улмаас хугацаа хоцорсон байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан нийт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 5 төсөл арга хэмжээ тутмын нэг нь хугацаандаа эхлээгүй, хэрэгжилт ямар нэг шалтгааны улмаас хоцорсон байна.

2.23. Төсөл, арга хэмжээ хугацаа хожимдох болсон шалтгааныг бүлэглэн авч үзвэл санхүүжилт болон тендерийн үйл ажиллагаатай холбоотой шалтгаанууд голлож байна. Ялангуяа тендер удаа дараа хойшлогдох, үнийн өсөлт инфляцийг тооцоолоогүйгээс хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

2.24. Судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг бүлэглэж үзэхэд дараах ангилал үүсэж байна. Үүнд:


Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хугацаа хоцорсон шалтгаан

№	Хариултын хувилбар	Саналын тоо (50)
Тендертэй холбоотой шалтгаан		10
1	Оролцогчид санал ирүүлээгүйгээс тендер 2 удаа зарлагдсан	2
2	Гадаадын компаниуд өндөр үнийн санал ирүүлж байсан тул 2 удаа тендер зарлагдсан	1
3	Төслийн зөвлөх шалгаруулах олон улсын нээлттэй тендер үнэ өндөр байснаас 3 удаа хойшлогдсон	1
4	Тендерийн маргаан гарсан	1
5	Тендер удаа дараа хойшлогдсон	4
6	Төслийн удирдагчийн сонгон шалгаруулалт удааширсан	1
Санхүүжилтээс шалтгаалсан		20
1	Санхүүжилт орж ирээгүй байгаа	3
2	Үнийн өсөлттэй холбоотой санхүүжилт дутсан	10
3	Газар чөлөөлөх, материал түлшний үнэ өссөн	1
4	Санхүүжилт дутуу орж ирсэн	2
5	Хөрөнгийн асуудал удаан шийдэгдсэн	1
6	Санхүүжилт оройтсон	3
Газрын асуудлаас шалтгаалсан		7
1	Газрын асуудал шийдэгдэхгүй байгаа	5
2	Газрын байршил өөрчлөгдсөн /барилгын/	2
Удирдах дээд байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалсан		6
1	СЯ-ны худалдан авах ажиллагааг эхлүүлэх зөвшөөрлийг хүлээдэг	2
2	Төсвийн тодотголын хуулиас шалтгаалсан	3
3	ЗГ хөрөнгийн баталгааг хугацаа хоцорч гаргасан	1
Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой		7
1	Зураг төсөл хугацаа хоцорсон	2
2	Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалсан	2
3	Ажил гүйцэтгэх хугацаагаа буруу тооцож тендерт ордог	1
4	Гадна дулаан, бохир усны шугам өөрчлөгдсөн	1
5	Нэмэлт ажлын гэрээ хийх шаардлагатай болсон	1

2.25. Дээрх хүснэгтээс харахад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд санхүүжилтийн болон тендерийн үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолоогүй, тухайн арга хэмжээнд нөлөөлж болох хөндлөнгийн хүчин зүйлсийг зөв төлөвлөж байх шаардлагатай байна.

2.26. Судалгаанд оролцогчид гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж буй өнөөгийн нөхцөл байдалд дараах дүгнэлтийг өгсөн байна. Үүнд, хуулийн уян хатан байдал, тухайн салбарын үйл ажиллагаа, арга хэмжээний онцлог, тендерт оролцсон

байгууллагуудын чадавхи, нөөц зэргийг сонгон шалгаруулалтад харгалздаг байх, томоохон тендерийг хэд хэдэн багц үйл ажиллагаагаар салган шалгаруулалт хийх нь зүйтэй зэрэг саналууд дэвшүүлсэн байна. (График 4-т үзүүлэв)



2.27. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх санал асуулгыг салбараар авч үзвэл, судалгаанд хамрагдсан ЭМЯ-наас авсан 18 асуулгын 77.8 хувь, ЗТБХБЯ-ны 23 асуулгын 26.1 хувь, БСШУЯ-ны 12 асуулгын 50.0 хувь, ЭБЭХЯ-ны 157 (давхардсан тоогоор) асуулгын 14.6 хувь хугацаа хожимдож хэрэгжиж байна гэжээ.

2.28. Эрүүл мэндийн салбарт барилгын газрын байршлыг өөрчилсөн, газрын асуудал шийдэгдээгүй, боловсролын салбарт үнийн өсөлттэй холбоотойгоор санхүүжилт дутсан шалтгаанууд төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаанд сөргөөр нөлөөлсөн гэжээ.

Дүн шинжилгээний ажлын явцад цуглуулсан нотлох зүйлс, шинжилгээний дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Улс, орон нутаг, салбарын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөргүйгээс хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь улсын эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг тодорхойлсон урьдчилсан судалгаа, нарийвчилсан тооцоо, дүн шинжилгээ хэрэгцээ, шаардлагыг харгалзан эрэмбэлэгдээгүй, улсын төсвийн хөрөнгийг жигд хүртээсэн байдалтай байна.

Хөрөнгө оруулалтын олон эх үүсвэр, үйл ажиллагааг цогц байдлаар уялдуулан зохицуулах, судалгаа, шинжилгээ, төсөвлөлт, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих үр дүнг тооцох, бүртгэж мэдээлэх үүрэг хариуцлагын эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалтын тогтолцоо хангалтгүй байна.

Хуулиар баталсан төсвийн хязгаарыг үндэслэн хөрөнгийн зардалд багтаан хөрөнгө оруулалтыг төлөвлөөгүйгээс эдийн засаг огцом өсөх үед зарлага адилхан өсч, хөрөнгийн хуваарилалтад сөргөөр нөлөөлөх магадлалтай байна.

Техник, эдийн засгийн үндэслэл нь боловсрогдоогүй, барилга барих газрын байршил шийдэгдээгүй, газрын зөвшөөрөлгүй, техникийн нөхцөл аваагүй, зураг төсөлгүй, зураг нь экспертизээр баталгаажаагүй, төсөв зохиогдоогүй, баталгаажилт хийгдээгүй барилга объектыг хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөж хууль, журмыг зөрчих явдал арилахгүй байна.

Томоохон хөрөнгө оруулалтын арга хэмжээг салбарын норм, норматив, стандартыг баримтлан, үндэслэлтэй төлөвлөөгүй, олон төсөл арга хэмжээг хүртээх байдлаар зэрэг эхэлдэг, санхүүжилтийг бууруулж баталж байгаагаас нөөц тарамдаж, хугацаа алдан хэрэгжилт удааширч, хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулаагүй нь төсөл арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

2011 онд батлагдсан Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т зөвхөн 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй томоохон төслүүдийг хамруулахаар тусгасан нь энэ дүнд хүрээгүй төслүүдэд холбогдох шаардлага, шалгууруудыг тавих, улсын болон бүс орон нутгийн хөгжлийн бодлого, бусад төслүүдтэй уялдуулах асуудлууд орхигдоход хүргэж болзошгүй байна.

Хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг улсын болон салбарын түвшинд, хэрэглэгчдэд ямар үр өгөөжтэйг нарийвчлан тооцоолдоггүй, тэдгээрт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоож хариуцлага тооцдоггүй байна.

Шинжилгээний ажлын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар:

- Дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөвлөлтийг уялдуулан улс орны эдийн засаг нийгмийн хөгжлийг хангахад чиглэсэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж батлан мөрдөх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахдаа мэргэжлийн байгууллагын тооцоо, дүгнэлтэд үндэслэн шийдвэрлэдэг эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд, үйл ажиллагааг цогц байдлаар уялдуулан зохицуулах удирдлага зохион байгуулалт, чиг үүргийн уялдааг дахин авч үзэж, холбогдох арга хэмжээ авах

Сангийн сайд Д.Хаянхярваад:

- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулан боловсруулж байх,
- Төсвийн тухай хууль, холбогдох журмаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, барилга байгууламжийг төлөвлөхөд баримтлах зарчмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах
- Төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, эрх бүхий байгууллагад танилцуулан, давтагдахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Худалдан авах ажиллагааг оновчтой, үр дүнтэй зохион байгуулаагүйгээс зарим төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байгаад дүн шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцдог байх.

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуунд:

- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, бүртгэл, мэдээлэл, дүн шинжилгээний нэгдсэн сан байгуулж оновчтой шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлэх
- Хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжийг тооцох, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тогтоож хариуцлагын механизм бий болгох



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Ч.РАДНАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ҮНДЭСНИЙ ХӨГЖИЛ,
ШИНЭТГЭЛИЙН ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-33-33, Факс: (976-11) 32-79-14

2012.04.03 № 1/240
танай 2012.03.29-ны № 590 -т

Албан бичгийн хариу

Танайхаас ирүүлсэн "2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хийсэн дүн шинжилгээний тайлан"-тай танилцлаа.

Тайлангийн дүгнэлтүүдтэй санал нийлж байгаагаас гадна шинжилгээний ажлын дүн, дүгнэлтэд үндэслэн гаргасан зөвлөмжүүдийг бүрэн дэмжиж байна.

Улсын Их Хурлын 2011 оны 57 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү тайлангийн зөвлөмжид дараах арга хэмжээг нэмж тусгах саналтай байна. Үүнд:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт:

➢ Үндэсний хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн нэгдсэн тогтолцооны цахим сүлжээг бий болгож яам, агентлагуудын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал боловруулах, төслүүдийг үнэлэх эрэмбэлэх, УХОХ-ийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, батлах, төсөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх шатны бүх үйл ажиллагааг багтаасан, интернетэд суурилсан системд шилжүүлэх, төслийн бүх процессыг хянах нөхцөлийг бүрдүүлэх.

Сангийн сайд Д.Хаянхярваад:

➢ Цахим сүлжээ болон хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн баазтай холбоотой хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, тухайн оны төсвийг УХОХ-тэй нягт уялдуулан боловсруулах.

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуунд:

➢ Төрийн болон орон нутгийн өмч, улсын хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн баазыг бий болгож, программ хангамжийн асуудлыг шийдвэрлэх замаар өгөгдөл, мэдээлэл цуглуулах, лавлагаа, тодруулга гаргах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг эрс сайжруулах.

➢ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлтийн ил тод байдал, өнөөгийн байдал ба хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой оруулах, тайлан, тооцоо, холбогдох бусад мэдээллийг шуурхай гаргах боломжийг хангаж, үнэн зөв, иж бүрэн мэдээлэл, судалгааны үндсэн дээр төлөвлөх, зөв, оновчтой шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зэрэг болно.

Хамтын ажиллагаанд талархсан,

ДАРГА



Ч.ХАШЧУЛУУН



Тайлбар 1

Тайлбар 2

Тайлбар 3



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2012 04 10 № 10/1900
танай _____ -ны № 591 -т


Санал өгөх тухай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
Б.БАТБАЯР ТАНАА

УИХ-ын 2011 оны 57 дугаар тогтоолын 2 дугаар заалтаар "Улсын төсвийн хөрөнгө оруулалтанд гүйцэтгэлийн аудит хийхдээ 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төслүүдийг сонгон, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран иж бүрэн хяналт, шинжилгээ хийж, авах арга хэмжээний саналыг цогц байдлаар боловсруулан 2012 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд танилцуулах" үүргийг Үндэсний аудитын газарт өгөгдсөний дагуу Улсын төсвийн 2012 оны төсөвт тусгагдсан 5 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хийсэн дүн шинжилгээний тайлантай танилцлаа.

Дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг зөвхөн Улсын 2012 оны төсвөөр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээгээр хязгаарлахгүй хэрэгжиж дуусаад Улсын комисс хүлээж авсан зарим төсөл, арга хэмжээг хамруулан мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан бодит байдалд нь хэмжилт хийж, чанар, үр дүнд нь үнэлэлт дүгнэлт өгсөн дүн шинжилгээ хийвэл илүү ач холбогдолтой болно гэж үзэж байна. Энэхүү тайлангаар Үндэсний аудитын газраас жил бүр улсын төсвийн хөрөнгө оруулалтад гүйцэтгэлийн аудит хийж тодорхой зөвлөмжүүдийг өгч ирсэн боловч зөрчил дутагдал арилахгүй байгаа нь харагдаж байна.

Иймд манай улсын хөрөнгө оруулалтын асуудал нь зөвхөн нэг яам, газрын шийдвэрлэж чадах асуудал биш болоод байгаа тул УИХ-ын 2011 оны 57 дугаар тогтоолд заасны дагуу Үндэсний аудитын газар, Сангийн яам болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хөрөнгө оруулалтын менежментийг боловсронгуй болгох талаар авах арга хэмжээний цогц саналыг боловсруулж УИХ-д танилцуулах саналтай байна.



Д.ХАЯНХЯРВАА

0001097

Тайлбар 4

Саналд өгөх тайлбар

- Тайлбар 1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг батлан мөрдөх тухай зөвлөмжид тусгасан учир өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
- Тайлбар 2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулан боловсруулах гэж зөвлөмжийг найруулав.
- Тайлбар 3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, бүртгэл, мэдээлэл, дүн шинжилгээний нэгдсэн сан байгуулж оновчтой шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлэх гэж зөвлөмжийг найруулав.
- Тайлбар 4. 2012 оны төсвийн хууль батлагдсантай холбогдуулан УИХ-ын 57 дугаар тогтоол гарсны дагуу 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төслүүдийг сонгон дүн шинжилгээг хийн тайлагнаж байна. ҮАГ-аас 2011 оны төсвийн хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж байгаа болно.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2012 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. 2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хийсэн дүн шинжилгээний тайланг баталсугай.

2. Дүн шинжилгээний тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд тус тус хүргүүлсүгэй.

3. Дүн шинжилгээний тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2012 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ү.Хүрэлбаатар, Сангийн сайд Д.Хаянхярваа, Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун нарт зөвөлсүгэй.

4. Дүн шинжилгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070086
tushaal

2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 5.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээний зөрчлийн түүвэр /ТЭЗ-аар/

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагчид	Төсөвт өртөг	Дүн шинжилгээнд хамрагдсан төсөл арга хэмжээ				5.0 тэрбумаас дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний тоонд эзлэх хувь / 137 ТАЗ /	
			Тоо	Дүн	Үүнээс зөрчилтэй			
					тоо	Дүн		
Техник, эдийн засгийн үндэслэлгүй төсөл арга хэмжээ								
1	XII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	95,435.0	5	84,035.0	2	2,074.2	9.5
2	XIX	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	71,460.4	8	65,300.0	4	5,375.0	
3		УЛААНБААТАР ХОТ	196,334.2	8	142,834.2	5	31,921.6	
4	XXIY	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	50,151.0	1	12,271.0	1	750.00	
5	XXY	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	11,137.0	1	11,137.00	1	11,137.00	
Дүн				23	315,577.20	13	51,257.80	
Газрын зөвшөөрөлгүй төсөл арга хэмжээ								
1	XII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	95,435.0	5	84,035.0	2	2,449.2	8.7
2	XIX	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	71,460.4	8	65,300.0	5	8,573.0	
3		УЛААНБААТАР ХОТ	196,334.2	8	142,834.2	4	29,421.6	
4	XXY	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	11,137.0	1	11,137.0	1	11,137.00	
Дүн				22	303,306.2	12	51,580.8	
Геологи, геодезийн дүгнэлтгүй төсөл арга хэмжээ								
1	XII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	95,435.0	5	84,035.0	2	2,499.2	8.7
2	XIII	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД	8,023.0	1	8,023.0	1	6,017.00	
3	XIX	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	71,460.4	8	65,300.0	3	5,375.0	
4		УЛААНБААТАР ХОТ	196,334.2	8	142,834.2	4	29,421.60	
5	XXIY	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	50,151.0	1	12,271.0	1	750.0	
6	XXY	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	11,137.0	1	11,137.00	1	11,137.00	
Дүн				24	323,600.2	12	55,199.8	
Техникийн нөхцөл аваагүй төсөл арга хэмжээ								
1	XII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	95,435.0	5	84,035.0	3	21,124.20	7.2
2	XIX	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	71,460.4	8	65,300.0	4	5,375.0	
3		УЛААНБААТАР ХОТ	196,334.2	8	142,834.2	1	5,721.6	
4	XXIY	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	50,151.0	1	12,271.0	1	750.0	
5	XXY	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	11,137.0	1	11,137.00	1	11,137.00	
Дүн				23	315,577.2	10	44,107.80	
Зургийн даалгавар өгөгдөөгүй, зураг төсөлгүй, зураг экспертизээр баталгаажаагүй төсөл арга хэмжээ								
1	XII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	95,435.0	5	84,035.00	1	375.0	10.2
2	XIX	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	71,460.4	8	65,300.0	4	5,375.0	
3		УЛААНБААТАР ХОТ	196,334.2	8	142,834.2	1	5,721.6	
4	XXI	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	34,110.0	3	33,100.0	2	2,200.0	
5	XXII	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	24,100.0	3	24,100.00	1	480.0	
6	XXIY	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	50,151.0	1	12,271.0	1	750.0	
7	XXY	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	11,137.0	1	11,137.00	1	11,137.00	
8	XX	ЗАМ ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	537,986.0	15	366,512.5	2	157,202.00	
9	XV	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР	5,000.0	1	5,000.0	1	2,630.0	
Дүн				45	744,289.70	14	185,870.6	
Төсөвгүй, төсвийн баталгаажуулалт хийлгээгүй төсөл арга хэмжээ								
1	XII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	95,435.0	5	84,035.0	1	375.0	10.2
2	XIX	ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	71,460.4	8	65,300.0	4	5,375.0	
3	XX	ЗАМ ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	537,986.0	15	366,512.5	2	157,202.00	
4		УЛААНБААТАР ХОТ	196,334.2	8	142,834.20	3	10,721.6	
5	XXI	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	34,110.0	3	33,100.0	2	2,200.0	
6	XXIY	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	50,151.0	1	12,271.0	1	750.0	
7	XXY	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	11,137.0	1	11,137.00	1	11,137.00	
Дүн				41	715,189.7	14	187,760.6	
Сонгон шалгаруулалт хийгдээгүй, ажил эхлэх зөвшөөрөл аваагүй төсөл арга хэмжээ								
1	XII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	95,435.0	5	84,035.0	5	22,999.20	27.0
2	XIII	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД	8,023.0	1	6,017.00	1	6,017.00	
3	XVI	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	36,380.90	1	31,046.5	1	1,875.00	
4	XVII	ХУУЛЬ ЗҮИ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	13,709.60	2	13,706.6	2	5,800	
5	XIX	ЭРДЭС БАЯЛАГ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	71,604.40	8	65,300.0	4	12,323.00	
6	XX	ЗАМ ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	537,986.0	15	366,512.5	11	366,512.5	
7		УЛААНБААТАР ХОТ	196,334.2	8	142,834.20	7	44,451.20	
8	XXI	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	34,110.0	3	33,100.0	3	4,204.5	
9	XXII	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	24,100.00	3	24,100.00	1	480.0	
10	XXIY	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	50,151.0	1	12,271.0	1	750.0	
11	XXY	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	11,137.0	1	11,137.00	1	11,137.00	
Дүн				48	790,059.8	37	476,549.4	
Нийт зөрчлийн тоо						112		

